

АЖИЛ МЭРГЭЖЛИЙН УРАЛДААНТ РЕАЛИТИ ШОУ ХӨТӨЛБӨРИЙН УДИРДАМЖ.

Нэг. Хөтөлбөрийн зорилго

Авто замын салбарын ажилчдын өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, шинэ техник технологи, ажлын арга, туршлага солилцох, түгээх, авто замын бүтээн байгуулалтын ажлыг олон нийтэд таниулж, сурталчлахад энэхүү ажил мэргэжлийн уралдаант реалити шоу хөтөлбөрийн зорилго оршино.

Хоёр. Ерөнхий зүйл

Авто замын салбарын ажил мэргэжлийн уралдаант реалити шоу хөтөлбөрийг 2 үе шаттайгаар зохион байгуулна.

I үе шат авто замын төслийн ажлын байрлалаас хамааран улсын хэмжээнд Зүүн, Говийн, Баруун, Хангайн, Төвийн 5 бүс болгон явуулна.

- Зүүн бүс: Хэнтий, Дорнод, Сүхбаатар
- Говийн бүс: Говьсүмбэр, Дундговь, Дорноговь, Өмнөговь
- Баруун бүс: Говь-Алтай, Ховд, Баян-Өлгий, Увс, Завхан
- Хангайн бүс: Баянхонгор, Архангай, Хөвсгөл, Өвөрхангай, Орхон, Булган, Сэлэнгэ
- Төвийн бүс: Төв, Дархан-Уул, Улаанбаатар хот

II үе шат нь дээрх 5 бүсээс төрөл бүрт эхний 2 байранд шалгарсан оролцогчийг Авто замчдын ажил мэргэжлийн уралдаант реалити шоунд оролцуулна.

Гурав. Байршил, хугацаа

I шатны ажил мэргэжлийн уралдаан дараах 5 бүс нутагт 8-р сарын 16-нд зэрэг болно.

Зүүн бүс-Хэнтий, Хэрлэн голын төмөрбетон гүүр, 265 у/м, хатуу хучилттай авто зам, 14.2 км хатуу хучилттай авто замын төслийн талбай

Говийн бүс-Дорноговь, Хамарын хийдийн 3 замын уулзвараас-Зүүнбаян чиглэлийн 20.0 км хатуу хучилттай авто замын эхний үе шатны төслийн талбай

Баруун бүс-Ховд, Ховд-Дөргөн сум чиглэлийн 40.7 км хатуу хучилттай авто замын төслийн талбай

Хангайн бүс-Архангай, Цэцэрлэг-Тосонцэнгэл чиглэлийн авто замаас Хорго, Тэрхийн цагаан нуур хүртэлх 13 км хатуу хучилттай авто замын төслийн талбай

Төвийн бүс-Улаанбаатар хот. Чингэлтэй дүүрэг, 7-р хороо. 149-р сургуулийн урд авто зам, авто зогсоолын төслийн талбайд тус тус болно.

II үе шатны ажил мэргэжлийн уралдаан буюу төгсгөлийн шатны реалити шоу УБ Дарханы замаас Дугана хад амралтын бааз хүртэлх 8 км замын ажлын төслийн талбайд 2024.09.06-ны 9:00 цагт эхэлж-09.16 нийг хүртэл хугацаанд уралдаан болон зураг авалтын ажил үргэлжилнэ.

Дөрөв. Уралдааны төрөл, хөтөлбөрийн шалгуур, шаардлага

4.1. Ур чадварын уралдааны төрөл

1. Замын инженер-1
2. Материалын инженер-1
3. Замчин-3

4. Автогрейдэрийн оператор-1
5. Экскаваторын оператор-1

4.2. Уралдааны шалгуур үзүүлэлт

1. Замын ажлын зураг унших чадвар, хэмжилтийн журнал хөтлөлт, ажлын аргачлал, зааварчилга өгсөн байдал, үндэслэл тайлбар г.м.
2. Лабораторийн ажилд өгсөн даалгаврын дагуу хийсэн шинжилгээ, үр дүн, баримтжуулалт
3. Ажлын зургийн дагуу, хугацаа, чанар, бэлтгэл ажил зэргээр дүгнэнэ.
4. Хугацаа, гадаргын жигд болон тэгш байдал, ТШ-ын хүлцэх алдаанд байгаа эсэх
5. Зургийн дагуу хажуу налуугийн хэмжээ хүрсэн эсэх, тэгш байдал, хугацаа, багийн бүрэлдэхүүний тоо

4.3. Тавигдах шаардлага.

1. Авто замын салбарт 3 аас доошгүй жил ажилласан, мэргэжлийн үнэмлэх, дипломтой байх, мөн оролцогч компани нь энэ жилийн татвар төлсөн гишүүн байгууллага байна.
2. Уралдаант реалити шоуны зураг авалтын үеийн ХАБЭА, галын аюулгүй байдлыг хангаж, кемпийн дэг журмыг мөрдөх
3. Уралдаанд оролцох хувийн бэлтгэл, багаж тоног төхөөрөмж, гэр майхан, хоол хүнс бэлтгэсэн байх
4. Уралдаант шоуны үеэр гарах асуудлыг тухай бүр багийн ахлагч нар зохион байгуулагч, найруулагч, шүүгч нартай зөвшилцөн хамтран шийдвэрлэнэ.

Тав. Оролцогчдыг бүртгэх, мэдүүлэг авах,

Нэг баг 2500000 төгрөгийн хураамжийг шагналын санд төвлөрүүлэх бөгөөд шагналын санг багийн болон тэмцээн тус бүрийн шагналт байруудад хуваарилан олгоно. Хураамжийг Монголын авто замчдын холбооны Хаан банкны 5029541678 тоот дансанд 2024 оны 8-р сарын 9-ний дотор байршуулах ба гүйлгээний утган дээр байгууллагын нэр болон “Ажил мэргэжлийн уралдаан” гэж бичсэн байна.

Оролцогчдын мэдүүлгийг 2024.08.09-ний дотор багууд албан бичгээр МАЗХ-нд ирүүлнэ. Мэдүүлэгт багийн гишүүдийн анкет, үндсэн ажилтан гэдгийг нотлох баримтуудыг хавсаргаж ирүүлнэ. ХУД, “Билэгт зам” ХХК-ийн байр. 206 тоот. Утас 70113288

Зургаа. Шагнал, урамшуулал

I үе шатны ажил мэргэжлийн уралдааны ялагчийг 5 бүс тус бүрт шалгаруулж эхний 2 байрыг шагнана. Мөн төрөл тус бүрт эхний 2 байрыг тусгай шагналаар шагнана.

II үе шатны Авто замчдын ажил мэргэжлийн уралдаан буюу реалити шоуны ялагчийг төрөл тус бүрт тодруулах бөгөөд шагналт байранд 2, 3-р байрыг тус тус шалгаруулна.

АЖЛЫН ХЭСЭГ